

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны нэгдүгээр сарын 21-ний 14 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 39 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр 21-ний өдрийн хуралдаанаас: Дагвадоржийн Бэлэгсайханыг Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн ХЭГ/105 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт

		<p>зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2016 оны нэгдүгээр сарын 21-нээс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны хоёрдугаар сарын 16-нд зохион байгуулахаар шийдвэрлэв.</p>
3	<p>Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дарга, 2. Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, 3. Иргэний бүртгэлийн газрын дарга, 4. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга, 5. Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга, 6. Микро, эдийн засгийн статистикийн газрын дарга, 7. Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга 8. Нэгдсэн бодлого, хамтын ажиллагааны газрын дарга, 9. Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга, 10. Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 11. Хүний нөөцийн хэлтсийн дарга. <p>2. Улсын бүртгэл, статистикийн</p>

ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг орон тооны гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар Сономцэрэнгийн Мэндсайханыг 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн томилох.

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга С.Мэндсайханд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/718 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны

		<p>шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус агентлагийн Хүний нөөцийн хэлтсийн дарга Шаравсэнгийн Оюунгэрэлийг 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн томилох2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Оюунгэрэлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА